



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.13 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 170 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс хооронд байнгын ачаа тээврийн “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг олгох, ашиглах, хяналт тавих үйл ажиллагаанд баримтлах удирдамж”-ийг хавсралтаар баталсугай.

2. Удирдамжид заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Автотээврийн бодлого зохицуулалтын газар (Э.Мөнхнасан), Салбарын хяналтын газар (М.Энхболд), Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Оюунтуяа), “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ (Б.Гүрсоронзон)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг нэгтгэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал боловсруулж, 2025 оны 07 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Автотээврийн бодлого зохицуулалтын газар (Э.Мөнхнасан)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Журам батлах тухай” 173 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Батболд)-д даалгасугай.

САЙД



Б.ДЭЛГЭРСАЙХАН

СС 000022

Зам, тээврийн сайдын 2025 оны
01 дүгээр сарын 09-ны өдрийн
А/63 дугаар тушаалын хавсралт



**УЛС ХООРОНД БАЙНГЫН АЧАА ТЭЭВРИЙН “С” ТӨРЛИЙН ЗОРЧИХ
ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ ОЛГОХ, АШИГЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Улс хооронд байнгын ачаа тээврийн “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг /цаашид “зөвшөөрлийн бичиг” гэх/ олгох үйл ажиллагааг хүнд сурталгүй, ил тод болгож, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хүлээх хариуцлагыг тодорхой болгох, холбогдох хууль, тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийг мөрдөх, стандарт, дүрэм, журмын шаардлагыг хангуулахад оршино.

Хоёр. Зөвшөөрлийн бичиг олгох, ашиглах талаар

2.1. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ

2.1.1. Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээр, стандартын шаардлага зэргийг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд ил тод мэдээлэх;

2.1.2. Зөвшөөрлийн бичиг олгоход хууль бус шаардлага тавих, бусдад давуу байдал олгох, хүсэлт хүлээн авахад хугацаа тогтоож, хүндрэл учруулан зохиомол хомсдол, үүсгэхгүй байх;

2.1.3. “Тээврийн хэрэгслийн нэгдсэн мэдээллийн сан” /цаашид “нэгдсэн мэдээллийн сан” гэх/-ийн хөгжүүлэлт хийх, цахим архив бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, хүний оролцоогүй болгох шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.4. Зөвшөөрлийн бичиг олгохтой холбоотой аливаа төлбөр хураамж үндэслэлгүй тогтоохгүй байх;

2.1.5. Зөвшөөрлийн бичгийг стандартын шаардлага хангаж, нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн мэргэшсэн жолооч бүхий тээврийн хэрэгсэлд олборлолтын үйл ажиллагаа эрхлэгчтэй болон худалдан авагч талтай харилцан тохиролцож байгуулсан тээвэрлэлтийн гэрээг үндэслэн ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэж байх;

2.1.6. Зөвшөөрлийн бичгийг ачаа тээврийн урсгалтай уялдуулан хилийн боомтуудад зөв зохистой хуваарилан олгох;

2.1.7. Уурхайгаас төмөр замаар тээвэрлэгдэж буй уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэгчид зөвшөөрлийн бичиг олгохдоо тухайн суурь бүтэц эзэмшигчтэй байгуулсан тээвэрлэлтийн гэрээг үндэслэх;

2.1.8. Автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл (AGV)-д зөвшөөрлийн бичгийг энэ удирдамжид заасан журмаар олгох;

2.1.9. Зөвшөөрлийн бичиг олгосон, татгалзсан, хүчингүй болгосон талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 24 цагт багтаан өөрийн цахим хуудсанд байршуулах;

2.1.10. Хилийн боомт тус бүрд тээвэрлэлтэд явж байгаа тээврийн хэрэгсэлд нэгдсэн тооллого зохион байгуулж, нийт тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөний аюулгүй байдал болон тээврийн хэрэгслийн техникийн ерөнхий шаардлага хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргуулж, холбогдох арга хэмжээ авах;

2.1.11. Тээврийн хэрэгслийн үзлэг, тооллогыг зохион байгуулахдаа хөндлөнгийн хяналт тавих зорилгоор төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно;

2.1.12. Тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой хариуцлагын гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, улирал бүр гэрээг дүгнэх.

2.2. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд

2.2.1. Нэгдсэн мэдээллийн санд шаардлагатай мэдээллээ үнэн зөв бүртгүүлэх;

2.2.2. Улс хоорондын ачаа тээвэрлэлт хийх зөвшөөрөл авахаар бүртгүүлсэн мэргэшсэн жолооч нь зөвшөөрлийн бичгийн хүчинтэй хугацаанд тухайн төрлийн зөвшөөрөлтэй өөр аж ахуйн нэгжийн автомашин жолоодож улс хоорондын тээвэрт оролцохгүй байх;

2.2.3. “Олон улсын автозамын тээвэрлэлтийн ачааны дагалдах бичиг”-ийг улс хоорондын тээвэрлэлт бүрд авч явах, автотээврийн хяналтын постуудад заавал бүртгүүлсэн байх;

2.2.4. Жолооч, ажилчдын ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, Автотээврийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн хууль болон бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;

2.2.5. Ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэл болон жолоочийн амь нас, эрүүл мэндийн, гэнэтийн ослын даатгалд заавал хамруулсан байх;

2.2.6. Үйлдвэрчний эвлэлийн гурван талт шинэчилсэн хэлэлцээрт заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хэрэгжилтийг харьяалах үйлдвэрчний эвлэлийн холбооноос хагас жил тутамд гаргуулж, дүгнэсэн байх;


2.2.7. Зөвшөөрлийн бичгийг тогтоосон хугацаанд ашигласан байх;

2.2.8. Хууль бус шаардлага тавьж тээвэрлэлтийн хэвийн үйл ажиллагаа алдагдуулахгүй байх;

2.2.9. Зөвшөөрлийн бичигтэй автомашиныг бусдад худалдах тохиолдолд хүчинтэй зөвшөөрлийн бичгийг олгосон байгууллагад буцааж хураалгасан байх.

Гурав. Зөвшөөрлийн бичиг олгох, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах талаар

3.1. Автотээврийн бодлого зохицуулалтын газар



3.1.1. Зөвшөөрлийн бичиг олголтын үйл ажиллагаа явуулахдаа аж ахуйн нэгж, иргэдэд хүнд суртал гаргах, чирэгдүүлэх, шан харамж авах зэрэг хууль бус ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.1.2. Зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагаанд бүрэн хяналт тавих, хөндлөнгийн хяналтын зөвлөл байгуулж, мэдээллээр хангаж, харилцан уялдаатай ажиллах;

3.1.3. Удирдамжийн 2.1.9-д заасан мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, 7 хоног тутам яамны удирдлагуудад танилцуулах.

3.2. Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар

3.2.1. Зөвшөөрлийн бичиг олголт, аж ахуйн нэгжүүдийн ашиглалттай холбоотой санал, гомдол хүлээн авах тусгай дугаар ажиллуулах;

3.2.2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, гомдлын дагуу хяналт шалгалтыг явуулж, холбогдох арга хэмжээ авах;

3.2.3. Зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагааг хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээр, энэхүү удирдамжийн дагуу явуулж байгаа эсэхэд хяналт шалгалт явуулж, холбогдох арга хэмжээ авах.

3.3. Салбарын хяналтын газар

3.3.1. Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт эрхлэгч аж ахуйн нэгж, жолооч нь хууль тогтоомжид заасан шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт явуулж, холбогдох арга хэмжээ авах;

3.3.2. Аж ахуйн нэгжүүдийн зөвшөөрлийн бичиг ашиглалтын байдалд хяналт шалгалт явуулж, холбогдох арга хэмжээ авах.

Дөрөв. Хүлээх хариуцлага

4.1. Зөвшөөрлийн бичгийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

4.1.1. Зөвшөөрлийн бичгийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн, тээврийн хэрэгслийг зөвшөөрлийн бичгийн хамт бусдад худалдан борлуулсан;

4.1.2. Ажил олгогч нь зөвшөөрлийн бичгийг жолоочид худалдсан, зөвшөөрлийн бичигтэй холбоотой хууль бус төлбөр, хураамж авсан;

4.1.3. Тээвэрлэлтийн гэрээ байгуулах, нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэхдээ хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;


4.1.4. Хил, гаалиар хуулиар хориглосон ачаа бараа тээвэрлэсэн, тээвэрлэхийг оролдсон;

4.1.5. Тээвэрлэлтийн гэрээ цуцлагдсан.

4.2. Зөвшөөрлийн бичиг олгохоос татгалзах

4.2.1. Удирдамжийн 2.1.12-т заасан хариуцлагын гэрээний үүргийн биелэлт хангалтгүй дүгнэгдсэн;

4.2.2. Энэхүү удирдамжийн заалтыг 3 буюу түүнээс дээш удаа зөрчсөн;



4.2.3.Тээвэрлэлтийн гэрээний үнэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын /хуучнаар/ 2022 оны А/233, 2023 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан ачаа тээврийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ачааны онцлог, тээвэрлэх зайг харгалзсан ачаа тээвэрлэлтийн өртөг зардлыг тооцох аргачлал, жишиг тарифаас хэтрүүлсэн.

Тав. Үр дүн

5.1. Стандарт шаардлага тогтоосон эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах эсэх асуудлыг шийдвэрлэсэн байх.

5.2. Зөвшөөрлийн бичиг олгох, улс хоорондын тээвэрлэлтийн үйл ажиллагааг зөв зохистой хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсруулсан байх.

5.3. Зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагаа ил тод болж, зохиомол хомсдол үүсэхгүй байх нөхцөл бүрдсэн байна.

___оОо___

